

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024.11.29.

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ</b>							
1.	Зорилт 1: Худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих.	-	ТЕЗ-ын худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан хувь	100	100	Худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих ажлын хүрээнд төлөвлөсөн 9 зорилтын хэрэгжилт 93 хувийн гүйцэтгэлтэй байна.	93.0%
1.1	Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг зохион байгуулна.	-	Төлөвлөгөөт хугацаанд тендер шалгаруулалтыг зохион байгуулсан хувь	100	100	Аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолыг үндэслэн Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 2024 оны 09 сарын 23-ны өдөр төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болон өдөр тутмын хэвлэлд зарлан мэдээлсэн. Үйл ажиллагааны явцад холбогдох шийдвэрээр 4 удаа өөрчлөн баталгаажуулж ил тод мэдээллэн ажилласан. Төлөвлөгөөнд 10,594,859,900 төгрөгийн төсөвт өртөг бүхий 47 төсөл, арга хэмжээг зохион байгуулахаар tender.gov.mn сайтад ил тод нийтэлсэн.  Хэрэгжилтийн явц 100%	100%

1.2	Тендерийг үнэлэх ажлыг зохион байгуулна.	-	Үр дүнг цахимд байршуулсан хувь	100	100	Тайлант хугацаанд 10,494,859,900 төгрөгийн төсөвт өртөг бүхий 46 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зарласан ба 46 тендер шалгаруулалтын урилгыг tender.gov.mn сайт болон байгууллагын цахим хаягт болон шилэн дансанд байршуулсан. 10,093,245,500 төгрөгийн төсөвт өртөг бүхий 37 төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу үнэлж, гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. Хэрэгжилтийн явц 80%	80%
1.3	Худалдан авах ажиллагааг тайлагнана.	-	Хуулийн хугацаагаар	2024 оны 01 сарын 05-нд цахимаар Сангийн яаманд илгээсэн	Дараа оны 01 сарын 15-ны дотор	Худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу бүтэн жилээр хуулийн хугацаанд буюу 2024 оны 01 дүгээр сарын 15-ны дотор Сангийн яаманд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлэхээр төлөвлөж байна. Хэрэгжилтийн явц 100%	100%
1.4	Үнэлгээний хорооны гишүүдээс “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” (АСМ), тайлбарыг гаргуулан хүлээн авч, мэдэгдэл, тайлбарын мэдээллийг АТГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд бүрэн оруулна.	-	Тухайн жилд байгуулсан үнэлгээний хорооны гишүүдийн тайлбар, мэдүүлгийн тоо	130	Тухайн жилд байгуулсан үнэлгээний хорооны гишүүдийн тоогоор	Үнэлгээний хорооны 280 гишүүний /давхардсан тоогоор/ зөвшөөрөл, ашиг сонирхлын мэдүүлгийг авч байгууллагын эрх бүхий албан тушаалтан АТГ-ын цахим сайтад /www.meduuleg.iaac.mn/ байршуулсан. Хэрэгжилтийн явц 100%	100%

1.5	Тендерт шалгаруулалтын талаар гарсан гомдолыг шийдвэрлүүлнэ.	-	Захиалагчийн талд шийдвэрлэгдсэн хувь	100	Тухайг жилд гарсан гомдлын хувиар	Тайлант хугацаанд 10,494,859,900 төгрөгийн төсөвт өртөг бүхий 46 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зарласан ба 3 тендер шалгаруулалтад Сангийн яам, Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт тус тус гомдол гарч хууль журмын дагуу шийдвэрлэсэн. Хэрэгжилтийн явц 50%	50%
1.6	Тендерт оролцогчдод давуу эрх олгох хуулийн заалтыг тендерийн бичиг баримтад тусган хэрэгжүүлнэ.	-	Дотоодын давуу эрх тооцохоор тусгасан тендерийн эзлэх хувь  Давуу эрх тооцож шалгарсан тендерийн хувь	100  5	100  10	2024 онд аймаг, сумдын Засаг дарга, төсвийн захирагчдын хэмжээнд 16,024,456,700 төгрөгийн төсөвт өртөг бүхий 91 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг төлөвлөж Дотоодын үйлдвэрлэл, аж ахуй нэгжийг дэмжих ажлын хүрээнд цахимаар зарласан 11,848,785 төгрөгийн төсөвт өртөг бүхий 56 төсөл, арга хэмжээнээс 1,060,250,000 төгрөг бүхий 7 тендер шалгаруулалтад орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, татвар төлдөг аж ахуйн нэгж бол тендерийн үнэлгээ хийхэд давуу эрх тооцсон.  Дотоодын давуу эрх тооцуулан гэрээ байгуулсан тендерийн тоо- 7  Хэрэгжилтийн явц 100 %	100%
1.7	Улс, аймаг, сумд, аж ахуй нэгж байгууллагын хөрөнгө оруулалтаар зарласан тендерийн техникийн тодорхойлолтод ногоон худалдан авалтын шаардлагыг тусгуулна.	-	Ногоон худалдан авалтын хувь	3	5	2024 онд аймаг, сумдын Засаг дарга, төсвийн захирагчдын хэмжээнд 16,024,456,700 төгрөгийн төсөвт өртөг бүхий 91 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг төлөвлөж ногоон худалдан авалтыг дэмжих ажлын хүрээнд 522,170.0 мянга төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн. Үүнээс 522,170.0 мянга төгрөг бүхий 6	100%

						төсөл арга хэмжээг цахимаар зарлаж, 522,170.0 мянга төгрөг бүхий 6 төсөл арга хэмжээг гэрээ байгуулж ажилласан.  Хэрэгжилтийн явц 100 %	
1.8	Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын ажлуудыг бараа материалыг дотоодоо худалдан авах боломж, нөхцөлийг бүрдүүлж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.	-	Тухайн жилд босго үнээс дээш тендерт дотоодын үйлдвэрээс худалдан авах барааг нийлүүлж байгаад хяналт тавина.	-	Тухайн жилд босго үнээс дээш тендерт дотоодын үйлдвэрээс худалдан авах барааг нийлүүлж байгаад хяналт тавина.	Аймгийн хэмжээнд 16,024,456,700 төгрөгийн төсөвт өртөг бүхий 91 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг төлөвлөж Дотоодын үйлдвэрлэл, аж ахуй нэгжийг дэмжих ажлын хүрээнд цахимаар зарласан 11,848,785 төгрөгийн төсөвт өртөг бүхий 56 төсөл, арга хэмжээнээс 1,060,250,000 төгрөг бүхий 7 тендер шалгаруулалтад орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, татвар төлдөг аж ахуйн нэгжүүд шалгарсан байна.  Хэрэгжилтийн явц 100 %	100%
1.9	Тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулна.	-	Цахим тендер шалгаруулалтын хувь	100	100	Тайлант хугацаанд 10,494,859,900 төгрөгийн төсөвт өртөг бүхий 46 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зарласан Хэрэгжилтийн явц 100%	100%
<b>ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ</b>							
2.	<b>Зорилт 2: Байгууллагын албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэн, үйл ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлж, чадварлаг, ёс зүйтэй, төрийн албыг төлөвшүүлэх.</b>	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	Дор дурьдсан арга хэмжээний дундаж дүнгээр	<b>Байгууллагын албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэн, үйл ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлж, чадварлаг, ёс зүйтэй, төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд хийгдэх 25 заалтын дундаж хэрэгжилт 93.2 хувьтай байна.</b>	93.2%
2.1.	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлийг үнэлэх.	-	Төлөвлөгөөний баталгаажилт,	100	100	Төрийн захиргааны 1, төрийн үйлчилгээний 2 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус хянан баталгаажуулсан. 2024 оны	100%

			тайлагналтын хувь			11 дүгээр сарын 10-ны дотор Төрийн захиргааны 1, төрийн үйлчилгээний 2 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гаргасан тайлан болон албан хаагчидтай байгуулсан нэмэлт гэрээний тайланг тус тус үнэлэх шатандаа явж байна. Хэрэгжилтийн явц 100%	
2.2.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Авлигын эсрэг 14 заалт бүхий байгууллагын албан хаагчид болон эбатны хариуцах төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсны дагуу 02.15-ны ХАСХОМ мэдүүлгийг гаргах явцад алдаа зөрчил илрээгүй болно. Хэрэгжилтийн явц 90.0%	90%
2.3.	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Байгууллагын ТЗ-4 ангиллын 1 албан хаагч ХАСХОМ хуулийн хугацаанд авлигатай тэнцэх газрын цахим системд тайлагнасан. Худалдан авах ажиллагааны газар байгуулагдсантай холбоотойгоор тус газрын дарга Б.Болд-Эрдэнийг шилжүүлэн томилохтой холбоотойгоор ХАСУМ холбогдох захиргааны байгууллагад хүргүүлсэн. Хэрэгжилтийн явц 100%	100%
2.4.	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, судлах, шийдвэрлүүлж, тайлагнана.	-	Өргөдөл, гомдлын тоо Шийдвэрлэлтийн хувь	- 100	Ирүүлсэн өргөдлийн тоогоор 100	Иргэдээс байгууллага, албан хаагчдад хандсан амаар, цахим сүлжээ, санал хүсэлтийн хайрцаг, нээлттэй утсаар гомдол ирээгүй байна. Иргэнээс 1 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэн иргэнд хариу хүргүүлсэн. 1-4 дүгээр улирлын өргөдөл гомдлын мэдээ, тайланг гаргасан. Хэрэгжилт: <ul style="list-style-type: none"> <li>2024.03.13-нд Т.Нацагмаа худалдан авах ажиллагааны ахлах</li> </ul>	100%

						<p>мэргэжилтний сул орон тоонд ажиллах хүсэлт гаргасан ба хуульд заасны дагуу Төрийн албаны тусгай шалгалтад хамрагдан тус албан тушаалд томилогдох тухай албан ёсоор мэдэгдэж тухайн иргэний өргөдлийг хаасан.</p> <p>Хэрэгжилтийн явц 100%</p>	
2.5.	Байгууллагын 2023 оны баримт бичгийг архивлах ажлыг зохион байгуулна.	-	Архивласан баримтын хувь	100	100	<p>Засгийн газрын 2023 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 312 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/294 дугаар захирамжаар аймгийн Худалдан авах ажиллагааны газрыг байгуулаад байна.</p> <p>Худалдан авах ажиллагааны газрын ББНШК-ыг 2024.05.15-ны өдрийн А/12 тушаалаар байгуулсан. Байгууллагын хурлаар 2024 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2024.05.15-ны өдөр баталсан ба 21 нэр төрлийн архивын хадгаламжын нэгжийг хариуцах албан хаагчтай нь гаргасаж баталсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байнга хадгалах 17</li> <li>- 70 жил хадгалах 1</li> <li>- Түр хадгалах 3 тус тус байна.</li> </ul> <p>Хэрэгжилтийн явц 100%</p>	100%
2.6.	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, журам стандартыг мөрдүүлж ажиллана.	-	Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь	100	100	<p>Байгууллагад ирсэн 193 албан бичиг байна.</p> <p>-Худалдан авах ажиллагаатай холбоотой 129 бичиг байна. Үүнээс хариутай 6 бичиг байна.</p>	100%

						<p>-Үйл ажиллагаатай холбоотой 64 бичиг байна. Үүнээс хариутай 15 бичиг байна. Байгууллагаас явсан 273 албан бичиг байна.</p> <p>-Худалдан авах ажиллагаатай холбоотой 225 бичиг байна.</p> <p>-Үйл ажиллагаатай холбоотой 48 бичиг байна.</p> <p>Үйл ажиллагаанд хяналт тавьж, журам стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд Архивын ерөнхий газраас зохион байгуулдаг Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан бэлтгэх анхан шатны мэргэжлийн сургалтат 1 албан хаагчийг хамруулсан. (Хамрагдсан хугацаа 2024 оны 02 дугаар сарын 14-нөөс 03 дугаар сарын 14)</p> <p>Хэрэгжилтийн явц 100%</p>	
2.7.	Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулна	-	Төсвийг үр ашигтай зарцуулсан хувь	100	100	<ul style="list-style-type: none"> <li>➢ 2024 оны жилийн батлагдсан төсөв 255,100,000 төгрөг 11 дүгээр сарын байдлаар 227,725,000 төгрөгний төсөв батлагдсан бөгөөд гүйцэтгэл 165,723,659 төгрөг, төсвийн хэмнэлт 62,001,341 төгрөг байна. Хэмнэгдсэн зардалд орон тоо дутуугаас цалин сан, эд хогшил урсгал засварын зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал гэх мэт зардлууд хэмнэгдсэн байна. 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэл 25,800,000 төгрөг.</li> <li>➢ 2026-2027 оны төсвийн төсөөлөл, 2025 оны төсвийн төслийг</li> </ul>	100%

						<p>боловсруулж 07-р сарын 08-нд хүргүүлэн ажилласан.</p> <p>Хэрэгжилтийн явц 100%</p>	
2.8.	Нийгмийн даатгал, татварын тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг гарган хуулийн хугацаанд хүргүүлнэ.	-	Хугацаандаа тайлагнасан байдлын хувь	100	100	<ul style="list-style-type: none"> <li>➤ 2024 оны 1-11 дүгээр сарын НД-ийн тайланг хугацаанд нь гаргаж баталгаажуулсан. /Тайлагнасан/ НДХэлтэст өргүй авлагагүй болно. / 12-р сарын тайлангийн хугацаа болоогүй./</li> <li>➤ Татварын 1,2,3 дугаар улирлын тайланг хугацаанд нь гаргаж баталгаажуулсан. /Тайлагнасан/ Татварт өргүй авлагагүй болно. 4-р улирлын тайлангийн хугацаа болоогүй.</li> <li>➤ 2024 оны 1-11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүрийн 2-ны дотор гаргаж ил тодын самбар, байгууллагын сайт шилэн дансанд байршуулж байна. Мөн өр авлагын дэлгэрэнгүй мэдээг хугацаанд нь гаргаж төрийн сангийн мэргэжилтэнээр баталгаажуулсан.</li> <li>➤ Шилэн дансанд төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө түүний гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тооны өөрчлөлт зэрэг мэдээлэлийг байршуулахаас 2024 оны 11 дүгээр сарын байдлаар:</li> <li>➤ Тухай бүр 110, сар бүр 44, хагас жил бүр 4, жил бүр 5 нийт 163</li> </ul>	100%



						мэдээг шилэн дансанд байршуулсан. Хэрэгжилтийн явц 100%	
2.9.	Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, тооллого зохион байгуулах, өмч эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээ дүгнүүлнэ.	-	Гэрээ дүгнүүлсэн хувь	100	100	<ul style="list-style-type: none"> <li>➤ Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж үндсэн хөрөнгийн тооллогыг хагас жилийн байдлаар зохион байгуулсан. Илүүдсэн дутсан хөрөнгө байхгүй. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.</li> <li>➤ Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр 1 ширхэг зөөврийн компьютерийг бүртгэх, 1 ширхэг зөөврийн компьютерийг балансаас балансад шилжүүлж авах, 1 ширхэг мэдрэгчтэй дэлгэцийг актлах, 2 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлэх шийдвэрийг ИТХ-аар шийдвэрлүүлж, захирамжийн хэрэгжилтийг Орон нутгийн өмчийн газар хүргүүлсэн.</li> <li>➤ Жилийн эцсээр элэгдлээ нөхсөн 5 ширхэг хөрөнгийг ӨХБЗөвлөлийн хурлаар шийдвэрлэж, хэрэгжилтийг ОНӨГазарт хүргүүлсэн байна. Жилийн эцсээр элэгдлээ нөхсөн 5 хөрөнгийг ӨХБЗөвлөлөөр хуралдаж саналыг ОНӨГазарт хүргүүлсэн байна.</li> <li>➤ 2024 оны өмч эзэмшүүлэх гэрээг байгуулсан.</li> </ul> Хэрэгжилтийн явц 100%	100%

2.10.	Удирдлагаас өгөгдсөн үүрэг, даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлнэ.	-	Үүрэг, даалгаврын биелэлтийн хувь	80	100	Удирдах ажилтны шуурхай зөвөлгөөн 20 удаа хуралдснаас 15 удаа суусан. /үлдсэн хуралд ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй байсан./ Зөвлөгөөнөөс байгууллагад хамааралтай 10 үүрэг, даалгаврын биелэлтийг гаргаж хугацаанд нь ХШҮДАХэлтэст хүргүүлж ажилласан. Хэрэгжилтийн явц 70%	70%
2.11.	Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах	-	Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байдал  Хэрэгжилт, хувь	Тусгасан  100	Дахин хянаж сайжруулах  100	Засгийн газар, аймгийн Засаг даргын шийдвэрээр худалдан авах ажиллагааны газар байгуулсан холбогдуулан газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/02 тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, хуульд нийцүүлэн өргөдөл, гомдол хүлээн авах тухай тусгасан. Дээрх ажлын хүрээнд байгууллагын шинэ сайтыг “Содон сольюшин” ХХКомпаниар гүйцэтгүүлж, шинээр цэс нээн байгууллагын гомдол хүлээн авах ажилтны мэдээлэл, хаяг, утас, майл хаягийг ил тод байршуулсан. Мөн байгууллагын гадаа самбарт мэдээлэл авах ажилтны мэдээллийг тавьсан. Хэрэгжилтийн явц 100%	100%

2.12.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах.	-	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	100	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2024 оны 01 дүгээр улиралд байгууллагын бүх албан хаагч эрт илрүүлэгийн шинжилгээнд хамрагдсан. Мөн говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулдаг Энхбилэг эмнэлэгт 2024 оны 05 дугаар сард байгууллагын 5 албан хаагч эрдсийн шинжилгээнд хамрагдаж холбогдох зардлыг нэг удаагийн тэтгэмж, урамшуулаллын данснаас гаргасан.  Хэрэгжилтийн явц 100%	100%
2.13.	“Нэг өрх-Нэг ажлын байр” төслийн хүрээнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах.	-	Хуваарилагдсан өрхийн орлого, мян.төг  Хуваарилагдсан өрхөөс ажил хийж байгаа хүний тоо  Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах болон мэргэжил олгох чиглэлээр хамтран ажилласан байдал  Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	-  1  100	-  1  100	Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулагдсантай холбоотойгоор “Нэг өрх-Нэг ажлын байр” төслийн хүрээнд хувиарлагдсан өрх одоогоор байхгүй байна. Иймд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт өрх хувиарлах тухай албан бичгээр хандаад байна. Тодорхой хуваарилсан өрхийн мэдээлэл ирээгүй. Хэрэгжилтийн явц 30%	30%
2.14.	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөг болгон хэрэгжүүлэх, албан хэрэг хөтлөлтөд уламжлалт Монгол бичиг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх. Албан хаагчдыг	-	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангалт, хувь  Монгол бичгийн сургалтад албан хаагчдаа	100  албан хаагч,	50  5 албан хаагч,	1. Худалдан авах ажиллагааны газрын гадна хаягийг Монгол бичиг, крилл, англиар хослуулан бичсэн. 2. Засаг даргын Тамгын газраас Төрийн албан хаагчдад зориулан Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн сургалтыг ЕБ-ын 5 дугаар сургуулийн багш	100%

	Монгол бичгийн сургалтад хамруулах, байгууллагын албан хэргийн үйл ажиллагаанд Монгол бичгийн программ хангамжийг нэвтрүүлэх		хамруулсан байдал, хувь  Албан хэрэг хөтлөлтөд Монгол бичгийг нэвтрүүлсэн байдал, хувь	100	50	Э.Олонцэцэг багшийн заасан дунд шатны сургалтад байгууллагын албан хаагчид хамрагдсан. 3. Архивын ерөнхий газарт Монгол бичгийн хэвлэмэл хуудасны Тушаалын бланк 50ширхэг А4 бланк 100 ширхэг А5 бланк 200 ширхэг авахаар захиалгыг хүргүүлсэн байна. Монгол бичгийн хэвлэмэл хуудасны албан бланкыг хэвлэлтээс аваад хос бичгээр албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг туршилтын журмаар хөтлөхөөр төлөвлөж байна. Говьсүмбэр аймгийн Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Э.Олонцэцэгээс Монгол бичгийн дунд шатны сургалтад хамрагдсан. Хамрагдсан хугацаа 2024 оны 01 дүгээр сарын 22-ноос 01 дүгээр сарын 29) Хэрэгжилтийн явц 100%	
2.15.	Хог хаягдын менежментийг сайруулах: 1.Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав байршуулах 2.Байгууллага дээрээ хог хаягдлыг ангилан ялгаж хэвших 3.Нийтийн цэвэрлэгээнд тогтмол оролцох 4.Хуваарилсан талбайг тогтмол цэвэрлэх 5.Байгууллагын эргэн тойрны 100м талбайн хог хаягдал,	-	Ангилан ялгасан хог, хаягдлын хэмжээ, тн Дахиварт тушаасан хог хаягдлын хэмжээ, тн Нийтийн цэвэрлэгээнд оролцсон байдал, тоо Хуваарт талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, тоо Цэвэрлэсэн талбайн хэмжээ, га	- - - - - -	50 кг 10 кг 20 удаа 20 удаа 2 га 25 кг -	1.Байгууллагын орчинд хог ангилах 3 ширхэг хүгийн савыг байршуулсан. 2.Ангилан ялгах 3 ширхэг хогийн саванд хогоо ялгаж хэвшсэн. 3.Нийтийн цэвэрлэгээ болон хувиарт талбайн цэвэрлэгээг хийдэг. Хог цэвэрлэгээний тайланг “Хоггүй Сүмбэр” цахим хуудсан байршуулсан. 4.2024 он эхэлснээс хойших хугацаанд хувиарт талбайн цэвэрлэгээг 20 удаа хийж гүйцэтгэсэн. 5. Нийтийн цэвэрлэгээ болон хувиарт талбайн цэвэрлэгээг хийдэг. Хог	70%

	<p>цас мөсийг цэвэрлэж, орчны тохижилтыг сайжруулах.</p> <p>6.Хог хаягдлын үйлчилгээний хөлсийг бүрэн төлөх</p> <p>7.Ногоон худалдан авалтыг дэмжих</p> <p>8.Ангилан ялгасан хог хаягдлыг дахиварт тушааж хэвших</p>		<p>Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ, тн</p> <p>Ногоон худалдан авалтын тоо / мөнгөн дүн</p>			<p>цэвэрлэгээний тайланг “Хоггүй Сүмбэр” цахим хуудсан байршуулсан.</p> <p>6. Хог хаягдалтай холбоотой төлбөр гардаггүй тул хамааралгүй.</p> <p>7.Хэмнэлтийн хуулийн дагуу ногоон худалдан авалт байгууллага дээр хийх шаардлагагүй.</p> <p>8. Ангилсан хогийг зориулалтын уутанд хадгалж, цэвэрлэгч зориулалтын саванд хуримтлуулдаг.</p> <p>Хэрэгжилтийн явц 70%</p>	
2.16.	<p>Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Бүх нийтээр мод тарих ажилд идэвхитэй оролцож албан хаагч тус бүр 10 -аас доошгүй, байгууллага тус бүр 50-аас доошгүй мод бутыг тарьж, арчилж ургуулах, ургуулах боломжгүй тохиолдолд мод тарьж ургуулах, арчлах зардлыг хандивлах. /Ойн тухай хуулийн 31.1 дэх заалт/</p>	-	<p>Шинээр тарьсан мод</p> <p>Нөхөн сэргээлтээр тарьсан мод</p> <p>Модны ургалтын хувь</p> <p>Талбайн хэмжээ, га</p>	-	<p>25</p> <p>25</p> <p>80 хувь</p> <p>0.7 га</p>	<p>Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 12-ны дээр “Бүх нийтээр мод тарих” арга хэмжээнд байгууллагын 5 албан хаагч оролцож, Говьсүмбэр 30 цэцэрлэгт хүрээлэнд 25 ширхэг хайлаас модыг тарьсан.</p> <p>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар болон намрын улиралд мод үржүүлгийн талбайд 50 ширхэг хайлаас модыг албан хаагчид тарьж, усалгааг бүрэн хийсэн. Ургалтын хувийг жилийн эцсийн байдлаар 80-иас багагүй байхаар тооцоолж цэнэг усалгааг хийсэн.</p> <p>Хэрэгжилтийн явц 80%</p>	80%
2.17.	<p>Байгууллагын ажилтнуудыг худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамруулж АЗ гэрчилгээтэй болгох</p>	-	<p>Шинээр АЗ гэрчилгээ авсан албан хаагчдын тоо -</p>	-	2	<p>2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан. “Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллага, түүний багш, ажилтанд тавигдах шаардлага, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалтын журамд</p>	100%

						зааснаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” /Шинэчилсэн найруулга/-аар Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх ажилтан бэлтгэх сургалт нь танхимын болон танхимын бус, бие даан сурах гэсэн хэлбэртэй болсон бөгөөд суралцах сонирхолтой хүн бүхэн холбогдох хөтөлбөрийг үнэ төлбөргүй бие даан үзэж, шалгалт өгөх боломжтой болсон холбоотойгоор орон нутагт худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх шалгалтыг авах ажилтан бэлтгэх сургалтад хамрагдсан. Мөн байгууллагын 3 албан хаагч, нийт 10 иргэн АЗ гэрчилгээ авсан байна. Хэрэгжилтийн явц 100%	
2.18.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодитой ажил төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	төлөвлөгөөний хэрэгжилийн хувь  авлига, ашиг сонирхлын зөрчил гараагүй байх	100  0	100  0	Авлигын эсрэг 14 заалт бүхий байгууллагын албан хаагчид болон эбатны хариуцах төлөлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсны дагуу 02.15-ны ХАСХОМ мэдүүлгийг гаргах явцад алдаа зөрчил илрээгүй болно. 2024 оны бүтэн жилийн байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно. Хэрэгжилтийн явц 90%	90%
2.19.	Байгууллагын албан хаагчдыг архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, албан байгууллага дотор болон бусад хэлбэрээр архидан	-	Байгууллагад зохион байгуулсан арга хэмжээний тоо-, Албан хаагчид архи согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт	-	1  0	Байгууллагын албан хаагчид архидан согтуурахтай тэмцэх хуулийг бие даан уншиж байгууллагаараа ярилцлага хийсэн. Архидан согтуурахын эсрэг “НАМАЙГ АЛГАС” аяныг дэмжиж буйгаа албан хаагчид цахим орчинд хувийн сошиал хаягаараа түгээж илэрхийлсэн. Албан хаагчид архи согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд өртөөгүй.	100%

	согтуурах явдлыг таслан зогсоох.		хэрэг, зөрчилд өртөөгүй байх			Хэрэгжилтийн явц 100%	
2.20.	Албан хаагчдын эрх зүйн боловсролд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.	-	Зохион байгуулсан эрх зүйн сургалтын тоо,  Хамрагдсан албан хаагчдын тоо	1  албан хаагч	1  5 албан хаагч	2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр эрх зүйн боловсролд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээний биелэлтийн хүрээнд байгууллагын 5 албан хаагчдад Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн шинэчлэл сэдвээр Д.Бээжин 1 цагийн сургалт зохион байгуулсан. 10 дугаар сарын 29-нд Хууль зүйн хэлтсээс байгууллагаараа Авлигын талаар сургалт авсан. Хэрэгжилтийн явц 100%	100%
2.21.	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт шилжин ирээгүй албан хаагчдыг шилжүүлж, бүртгэлжүүлэх.	-	Орон нутагт бүртгэлтэй албан хаагчдын эзлэх хувь	100	100	Сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд тухай бүрт нь өгч ажилласан. Одоо ажиллаж байгаа албан хаагчид 100 хувь орон нутагт бүртгэлтэй байна. Хэрэгжилтийн явц 100%	100%
2.22.	Төрийн албан хаагчийг томилохдоо “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын зохицуулалтын дагуу зохист хэлбэрүүдийг ашиглан хууль зөрчихгүй ажиллах	-	Журмын хэрэгжилтийн хувь  Шилжүүлэн, сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо	-	100  2	Засгийн газрын 2023 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 312 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/294 дугаар захирамжаар аймгийн Худалдан авах ажиллагааны газрыг байгуулсан. Үүнтэй холбоотойгоор Орон нутгийн өмчийн газраас Худалдан авах ажиллагааны газарлуу 5 албан хаагчийн	100%

						хууль, журмын дагуу шилжүүлэн ажилласан. Хэрэгжилтийн явц 100%	
2.23.	Угийн бичгийг хөтлөх үндэсний уламжлалыг хэвшүүлэх Байгууллагын гадна хаягжилтыг хос бичгээр болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	-	Сургалт нөлөөллийн ажил; Угийн бичиг хөтөлж буй өрх Хаягаа хос бичгээр болгосон байгууллагын тоо	-	5  1	Угийн бичиг хөтлөлтийн сургалтыг 2023 онд Насан туршийн боловсролын төвөөс бүх албан хаагч авсан. Угийн бичиг хөтлөлтийн уламжлалыг бии болгох үүднээс албан хаагчид өөрсдийн угсаагаа судлах үйл ажиллагааг эхэлсэн бодит үзүүлэлттэй байна. Хэрэгжилтийн явц 100%	100%
2.24.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 06-нд байгууллагын дотоод сургалтаар орж, тус хуулийн талаар хэлэлцсэн. Энэхүү сургалтын байгууллагын жолооч Д.Бээжин зохион байгуулсан байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай нэгдсэн сургалтанд албан хаагчид бүгд хамрагдсан. Хэрэгжилтийн явц 100%	100%
2.25.	Төсвийн сахилга батыг хангаж хяналт шалгалтын байгууллагаар “зөрчилгүй” ажиллах	-	Аудитын дүгнэлт	-	“Зөрчилгүй” дүгнэгдэх	Төсвийн сахилга батыг хангаж, байгууллагын цахим сайтад төсөвтэй холбоотой мэдээллийг тухай бүрт нь ил тод байршуулж, хяналт шалгалтын байгууллагаар алдаа, зөрчилгүй ажиллах тал дээр анхаарч ажиллаж байна. Хэрэгжилтийн явц 100%	100%
<b>ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ</b>							
3.	<b>Зорилт 3: Тендерт оролцогч, захиалагч нарт мэргэжил арга зүйгээр</b>	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	Дор дурьдсан арга	<b>Тендерт оролцогч, захиалагч нарт мэргэжил арга зүйгээр хангах, тэгш хүртээмжтэй мэдээллээр хангах ажлын</b>	92.7%



	<b>хангах, тэгш хүртээмжтэй мэдээллээр хангах.</b>				хэмжээний дундаж дүнгээр	<b>хүрээнд 11 зорилтыг 92.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.</b> Хэрэгжилтийн явц 92.7	
3.1.	Харьяа байгууллагын худалдан авах ажиллагаанд хяналт тавьж, хууль, тогтоомжийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангана.	-	Зөвлөмж, арга зүйгээр хангасан хангасан байдлаар	100	100	Сумдын Засаг дарга болон бусад байгууллагуудын 5,608,723,900 төгрөгийн төсөвт өртөг бүхий 54 төсөл арга төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянан төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн системд байршуулахад зөвлөмж өгч ажилласан. Сумдын Засаг дарга, сумын Засаг даргын Тамгын дарга, мэргэжилтнүүдэд худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулж холбогдох асуултад арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Аймгийн бүх цэцэрлэг сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч, АЗ гэрчилгээтэй ажилтнуудад 2024 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотой сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний хооронд, 11 дүгээр сард сумдын төрийн сан, тус байгууллагуудын нягтлан бодогч нарт тендер шалгаруулалтыг зохион байгуулах сургалт тус тус хамруулсан. Хэрэгжилтийн явц 100%	100%
3.2.	Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох цахим сургалтыг орон нутагт зохион байгуулна.	-	Сургалт зохион байгуулсан байдлаар	100	100	2023 онд АЗ-н танхимын сургалтын зохион байгуулж, Төрийн байгууллагын 121 албан хаагчийг хамруулсан. 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан. "Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалт эрхлэх	100%

						байгууллага, түүний багш, ажилтанд тавигдах шаардлага, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, шалгалтын журамд зааснаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” /Шинэчилсэн найруулга/-аар Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх ажилтан бэлтгэх сургалт нь танхимын болон танхимын бус, бие даан сурах гэсэн хэлбэртэй болсон бөгөөд суралцах сонирхолтой хүн бүхэн холбогдох хөтөлбөрийг үнэ төлбөргүй бие даан үзэж, шалгалт өгөх боломжтой болсон холбоотойгоор орон нутагт худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх шалгалтыг авах ажилтан бэлтгэх сургалтад хамрагдсан. Хэрэгжилтийн явц 100%	
3.3.	Салбарын хүрээнд шинжлэх ухааны судалгаан дээр үндэслэн иргэд, албан хаагч, төр, төрийн бус байгууллагатай хамтран шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг нэвтрүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	100	100	Төрийн худалдан авах ажиллагааны газар, Худалдан авах ажиллагааны газрын албан хаагчидтай хамтран Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг орон нутагтаа зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагааг иргэдэд сургалчлах зорилгоор <a href="http://www.gs.spa.gov.mn">www.gs.spa.gov.mn</a> сайтыг шинээр бий болгоод байна. Хэрэгжилтийн явц 50%	50%
3.4.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд иргэд, байгууллага, хамт олныг	-	Хамрагдсан албан хаагчдын тоо	-	7 50	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2024 оны 01 дүгээр улиралд байгууллагын бүх албан	100%

	хамруулах, идэвхитэй оролцоог хангаж хамтран ажиллах.		Хамрагдалтын хувь	-		хаагч эрт илрүүлэгийн шинжилгээнд хамрагдсан. Мөн говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулдаг Энхбилэг эмнэлэгт 2024 оны 05 дугаар сард байгууллагын 5 албан хаагч эрдсийн шинжилгээнд хамрагдаж холбогдох зардлыг нэг удаагийн тэтгэмж, урамшуулаллын данснаас гаргасан. Байгууллагын жолооч Д.Бээжин Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд зөв хооллолт сэдвээр аймгийн эрүүл мэндийн газрын 15 албан хаагчид 1 цагийн сургалт, эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг заасан.  Хэрэгжилтийн явц 100%	
3.5.	Байгууллагууд албан ёсны цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан нээлттэй мэдээллийг байршуулах, олон нийтэд ил тод мэдээлэх.	-	Хуулийн хэрэгжилт, хувь	100	100	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8-р зүйлд заасан холбогдох мэдээллийг байгууллагын <a href="http://www.gs.spa.gov.mn">www.gs.spa.gov.mn</a> сайтад тухай бүрт нь байршуулсан. Хэрэгжилтийн явц 100%	100%
3.6.	Төрийн үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж, дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах.	-	ERP системийг нэвтрүүлэлтийн хувь Албан бичиг хэргийг цахимжуулалтын хувь	Нийт албан хаагчийн тоогоор  100%	Нийт албан хаагчийн тоогоор  100%	ХААГазар шинээр байгуулагдсантай холбоотойгоор и-монголиа академиас 2024 оны 01 дүгээр улиралд шинээр эрх авч, ERP системийг байгууллагын албан хаагчдад 100% нэвтрүүлж ажилласан. Манай байгууллагад ирсэн албан бичгийг холбогдох албан хаагчдад тухай бүрт нь шилжүүлж, өөрт холбогдох бичгийг тухай бүрт нь шийдвэрлэж ажиллаж байна.	100%

						Нийт 103 бичиг ирж, 21 албан бичиг холбогдох байгууллагуудруу явуулсан байна. Хэрэгжилтийн явц 100%	
3.7.	Албан ажлаар гадаад улсруу явахдаа аймгийн Засаг даргад мэдэгдэж зөвшөөрөл болон зөвлөмж, чиглэл авч байх, 7 хоногт багтаан бичмэл байдлаар тайлан ирүүлэх	-	Зөвшөөрөл авсан эсэх  Хугацаанд нь тайлан ирүүлсэн эсэх	Тухай бүрт	Тухай бүрт	2024 оны 01 дүгээр сарын 12 дугаар сар хүртэл байгууллагын нэг ч албан хаагч албан ажлаар гадаад улсруу яваагүй байна.  Хэрэгжилтийн явц 100%	100%
3.8.	Говьсүмбэр аймаг байгуулагдсаны 30 жилийн ой, “Боржигин наадам”-ыг тохиолдуулан байгууллага бүр тохижилт бүтээн байгуулалтын 1-2 ажил санаачлан зохион байгуулах /нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах/	-	Санаачилсан ажлын тоо  Хэрэгжилтийн хувь	-	1  100	“Боржигин наадам”-тай холбоотойгоор Талын Илч ОНӨААТҮГ-аас 2 цэвэр усны худаг бэлдэн усаар хангах ажлыг зохион байгуулсан. Мөн байгууллагын хэмжээнд наадмын талбайд 1 гэр барьж, гадна болон дотоодын зочдыг хүлээн авч, албан хаагчид зочдод хүлээн авах ажилд хамрагдсан. Хэрэгжилтийн явц 100%	100%
3.9.	Говьсүмбэр аймаг байгуулагдсаны 30 жилийн ой, “Боржигин наадам”-ыг тохиолдуулан байгууллагын гадна, дотоод өнгө үзэмжийг сайжруулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	Байгууллагын дотоод өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд Цахим дэлгүүрээс шалгарсан "Ухаалаг дэлгэц"-ийг 6.1 сая төгрөгөөр худалдан авж үр дүнг нийтэлсэн. Мөн байгууллагын ил тодын самбар хийсэн. 30 жилийн ойг угтан 3 удаагийн гадна талбайн цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилтийн явц 100%	100%
3.10	Монгол бичгийг иргэдэд сурталчлан түгээн дэлгэрүүлнэ.	-	Зохион байгуулах арга хэмжээний тоо	1	1	Засаг даргын Тамгын газраас Төрийн албан хаагчдад зориулан Монгол бичгийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн сургалтыг ЕБ-ын 5 дугаар сургуулийн багш	80%

						<p>Э.Олонцэцэг багшийн заасан дунд шатны сургалтад байгууллагын албан хаагчид хамрагдсан.</p> <p>Архивын ерөнхий газарт Монгол бичгийн хэвлэмэл хуудасны Тушаалын бланк 200 ширхэг А4 бланк 200 ширхэг А5 бланк 500 ширхэг авахаар захиалаг хэвлүүлэн авсан.</p> <p>2025 оноос хос бичгээр албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг туршилтын журмаар хөтлөхөөр төлөвлөж байна.</p> <p>Хэрэгжилтийн явц 80%</p>	
3.11	<p>Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, Төрийн албаны хуулийн хүрээнд мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.</p>	-	<p>Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн-Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо 5-аас доошгүй</p>	5-аас доошгүй	5-аас доошгүй	<ol style="list-style-type: none"> <li>Архивын ерөнхий газраас зохион байгуулдаг албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан бэлтгэх анхан шатны мэргэжлийн сургалтад байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч С.Маралмаа хамрагдаж амжилттай төгссөн.</li> <li>Говьсүмбэр аймгийн татварын газраас "Хариуцлагатай татвар төлөгч 2024" арга хэмжээний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Татварын хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаар сургалтад нягтлан бодогч А.Аасүрэн хамрагдсан.</li> <li>2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан мэргэшсэн ажилтанг бэлтгэх, шалгалт авах ажилтны</li> </ol>	100%

						<p>сургалтад ХАА мэргэжилтэн Г.Номин-Эрдэнэ хамрагдсан.</p> <p>4. Сэтгүүлч Т.Болдбаатрын Монгол эрхүний амин асуудал, гэр бүлийн үнэ цэнэ сэдэвт сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 23-нд зохион байгуулж, байгууллагын 5 албан хаагч сургалтад хамрагдсан.</p> <p>5. 2024 оны 04 дүгээр сарын 29-нд Дуу бүжгийн Боржигон чуулгад зохион байгуулагдсан Төрийн албаны шинэчлэл сэдэвт сургалтад байгууллагын 5 албан хаагч оролцсон.</p> <p>Хэрэгжилтийн явц 100%</p>	
	<b>ХЭРЭГЖИЛТ</b>						<b>93.11</b>

*Төлөвлөгөө тайлагнасан:*

***Төсвийн Шууд захирагч***

ХААГАЗРЫН ДАРГА  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

/Б.БОЛД-ЭРДЭНЭ/

(огноо)

*Тэмдэг*

.....

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:  
ХААГазрын дарга Б.Болд-Эрдэнэ  
Утас:88204869  
Цахим шуудангын хаяг: [bolderdene@gs.spa.gov.mn](mailto:bolderdene@gs.spa.gov.mn)